



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 1/53

Алтай хот

Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн
өвсийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн 200 тонн буюу 10000 боодол өвсийг сумдад олгох хуваарийг хавсралтаар баталж, нэг боодлыг 10,000 төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг аймгийн гамшгийн санд төвлөрүүлсүгэй.

2.Өвсийг зориулалт бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар), Онцгой байдлын газар (Ц.Лувсанжамц), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР